

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
ГОНЧИГЖАВЫН БАТМӨНХИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
<b>Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”</b>								
1	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Гаалийн байгууллагын 2023 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайландаа хорио цээрийн чиглэлийн асуудлуудын биелэлтийг хүргүүлсэн. 2.Монгол Улсын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хооронд хорио цээрийн хяналтын чиглэлээр 3 протокол байгуулсан, 5 Гаалийн газар 5 санамж байгуулсан.	1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирын хяналттай холбоотой эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах 2.”Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт” зэрэг холбогдох тогтоол, шийдвэрийн хорио цээрийн хяналттай холбоотой заалтын 2024 оны эхний хагас жилийн тайллан гаргах 3.Гаалийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирын хяналтын чиглэлээр хөрш зэргэлдээ болон	Засгийн газрын хөтөлбөр болон бусад тогтоол, шийдвэр, биелэлт, хуулийн хэрэгжилтийг гаргасан Хорио цээрийн чиглэлийн албан хаагчдын 20 ажлын байрны тодорхойлолтыг ГЕГ-ын даргын 2024 оны А/103 тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж шинэчлэн боловсруулсан. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн, экспортлох эрх хүсч хүсэлт гаргасан 15 аж ахуй нэгжийн холбогдох материалд хяналт хийж, баталгаажуулан ХХААХҮЯ-д уламжилсан. “Тэжээлийн амьтны уураг болон өөх, тос экспортлох үеийн хорио цээрийн шаардлагын Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар Болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн Ерөнхий Газар хоорондын протокол”-ыг батлуулахад бэлэн болгосон. Зоонозын халдварын хил дамнах эрсдэлээс сэргийлэх, хяналт тандалт хийх 2024-2027 оны төлөвлөгөөгээг БНХАУ-ын мэргэжлийн байгууллагатай батлуулсан. Угаасан ноос ноолуурын 3, техникийн болон ясны тос, уургийн 4 үйлдвэрт БНХАУ-ын ГЕГ, МЭЕГ- тай хамтран эрсдэлийн үнэлгээг хийсэн.  <b>Хүрсэн түвшин:</b> Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт зэрэг бодлогын баримтуудын хэрэгжилтийг гаргасан.	01.01- 06.10	95	

				бусад улстай протокол, санамж бичиг байгуулах, санал өгч ажиллах	БНХАУ-ын гаалийн болон мэргэжлийн байгууллагатай 1 протокол, 1 төлөвлөгөө, 1 эрсдэлийн үнэлгээ, 1 хамтарсан хурал, БНСУ-тай 1 төлөвлөгөө зэрэг арга хэмжээ зэрэг хорио цээрийн хамтын ажиллагааг хангаж, барааны экспорт, хорио цээр, аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг тохирсон.		
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Ургамал, хамгааллын тухай, Мал амьтны эрүүл мэндийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, ажлын хэсэгт ажилласан. 2.Гаалийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хууль эрх зүйн чадавхийг бэхжүүлэх зорилгоор 2023 оны эхний хагаст ГЕГ-ын даргын 4 тушаал батлуулж, хэрэгжилтийг хангулсан.	1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэл тус бүрээр заавар боловсруулах 2.ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэх саналыг боловсруулж, холбогдох газар, хэлтэст хүргүүлэх 3.Засгийн газрын 2014 оны 233 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны эрсдэлийг тодорхойлох шалгуур, үзүүлэлт", Монгол Улсын Шадар сайдын 2021 оны "Жагсаалт шинэчлэн батлах тухай" 20 дугаар тушаалд дүн шинжилгээ хийж, ГЕГ-ын "Эрсдэлийн удирдлагын журам"-д тусгах замаар	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллан, УИХ-ын Чуулганаар хэлэлцүүлж, батлуулсан. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаанд хяналт тавих тухай, Улсын хилийн боомтын тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай" Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт оруулах 21 саналыг егсөн. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт ашиглах зааврын загвар, зааврын нэр, төрлийн жагсаалтыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 06/06 тоот шийдвэр гарсаны мөрөөр Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн A/380 тоот тушаалаар батлуулсан. Хорио цээрийн хэлтсийн ажлын дүгнэх 12 шалгуур үзүүлэлт, газар хороодын хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг үнэлэх 6 шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, ГЕГ-ын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Аргачлал, тайлагнах хугацааг шинэчлэн батлах тухай" A/190 тушаалын 1.12 болон 2.7 дугаар хавсралтаар батлуулсан. <b>Хүрсэн түвшин:</b> 2 хуулийг шинэчлэх батлуулах, 6 хуулинд санал өгөх, 2 заавар, журмыг гаргаж, хорио цээрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн орчныг бурдуулэхэд ахиц гарсан	01.01-06.10	95

				хүчингүй болгох асуудлыг судлах. 4. Сангийн сайдын 253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан ачаа, тээврийн хэрэгслийн халдвартгүйжүүлэлтийн үнийн тарифт өөрчлөлт оруулах эсэх талаарх холбогдох судалгааг гаргаж, саналыг холбогдох Газар, хэлтэст хүргүүлэх 5. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах			
3	Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурисан хяналтыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Гаалийн хорио цээрийн хяналтад хамрагдаж байсан импортын 2301 бараанаас улбар шар төлвийн 121 барааг хорио цээрийн хяналтын чиглэлээс чөлөөлсөн.	1. Хорио цээрийн хяналтад хамрагдах барааны эрсдэлийн шалгуурыг боловсруулж эрсдэлд суурисан хяналт шалгалтыг хэрэгжүүлж улаан төлөвт шалгагдах барааны тоог бууруулах судалгааг хийж, Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй 3 удаагийн уулзалтыг хийж, хорио цээрийн эрсдэлийн шалгуурыг гаалийн эрсдэлийн шалгууртай уялдуулан тооцох программын даалгаврыг боловсруулсан.  2. Хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурисан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгох	Эрсдэлийн шалгуурыг боловсруулж эрсдэлд суурисан хяналт шалгалтыг хэрэгжүүлж улаан төлөвт шалгагдах барааны тоог бууруулах судалгааг хийж, Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй 3 удаагийн уулзалтыг хийж, хорио цээрийн эрсдэлийн шалгуурыг гаалийн эрсдэлийн шалгууртай уялдуулан тооцох программын даалгаврыг боловсруулсан.  “Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх журам”-д хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлээр тусгувулах саналыг өгсөн.  Вэб хуудсаар эмийн хяналтын чиглэлээр 2 удаа, химийн хорт болон аюултай бодисын хяналтаар 3 удаа, хүнсний аюупгүй байдлын чиглэлээр 3 удаа, ургамлын хорио цээрийн чиглэлээр 2 удаа, мал эмнэлгийн чиглэлээр 2 удаа тус тус зөвлөмж, мэдээлэл өгсөн.	01.01-06.10	90

				<p>3. Гаалийн эрсдэлийн нэгдсэн удирдлагын журмыг ЭҮХ-тэй хамтран боловсруулж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгоход санал өгөх</p> <p>4. Экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл зэрэг баталгаажуулалтын баримт бичгийн олголт Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжиж буйтай холбогdon бэлтгэл ажлыг хангах, эрх зүйн зохицуулалтын талаар санал хүргүүлэх</p> <p>5. Гадаад худалдаа эрхлэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах</p>	<p>SPS-ийг хэрэгжүүлэх хүрээнд БНСУ-тай “Чөлөөт худалдааны гэрээ”-г байгуулах ажлын хэсгийн ээлжит хурлыг зохион байгуулсан.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b></p> <p>Гаалийн харьяа газар, хороодод гэрчилгээ мэдэгдлийн 90 хувь шилжиж, төвлөрлийг сааруулж, үйлчилгээг түргэн шуурхай болгосон нь ноднингийн мөн үетэй харьцуулахад экспортын гэрчилгээ 1-2 цагт, импортын мэдэгдэл 2-3 цагт материал бүрэн тохиолдолд цахимаар олгогдож байна.</p> <p>Гаалийн эрсдэлийг хорио цээрийн эрсдэлтэй уялдуулах журмын төслийг боловсруулсан.</p> <p>SPS-ийг хэрэгжүүлэх хүрээнд БНСУ-тай “Чөлөөт худалдааны гэрээ”-г байгуулах ажлын хэсгийн ээлжит хурлыг зохион байгуулсан.</p> <p>Вэб хуудсаар эмийн хяналтын чиглэлээр 2 удаа, химиин хорт болон аюултай бодисын хяналтаар 3 удаа, хүнсний аюупгүй байдлын чиглэлээр 3 удаа, ургамлын хорио цээрийн чиглэлээр 2 удаа, мал эмнэлгийн чиглэлээр 2 удаа тус тус зөвлөмж, мэдээллийг гадаад худалдаа эрхлэгч нарт өгсөн.</p>		
4	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг	2024 онд нэмэгдсэн шалгуур үзүүлэлт	Хорио цээрийн хэлтсийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж,	Хорио цээрийн хэлтсийн түвшинд нэгжийн эрсдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн, түүний үндсэнд бууруулах арга хэмжээ авах чиглэлээр судалж ажилласан. Үүнд: Байгууллагын соёл-26,	01.01-06.10	100

		боловсронгий болгох ажлын хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар	тул 2023 онд төлөвлөгөөгүй.	эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн байна.	Удирдлагын манлайлал-25Ажлын байранд нөлөөлөх физик, хими, биологийн хүчин зүйл -4, Ажилчдын эрүүл мэндийн эрсдэл-12  Ажлын байр болон ажилчид хоорондын харилцаа, нийгмийн хангамжийн сэтгэл ханамж - 28 гэсэн судалгааг авахуулж, эрсдэлийг бууруулах цаашид авах арга хэмжээг тодорхойлсон.  <b>Хүрсэн түвшин:</b>  Нэгжийн эрсдэлийг тодорхойлох 5 бүлэг, 95 асуумжаар судалгаа авч, ХЦХ-ийн өнөөгийн эрсдэлийн тодорхойлсон.	
--	--	---	-----------------------------	---	---	--

**Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”**

1	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Олон улсын хүний хөл хориот өвчний хяналт тандалтын мэдээг өдөр бүрийн мэдээнд дүн шинжилгээ хийж, ЭМЯ, бусад холбогдох газруудтай эрсдлийн харилцаа холбоо үүсгэн ажилласан. Улсын хилээр орсон 415687 (дотоод 415687, гадаад 107776), улсын хилээр гарсан 502341 (дотоод 409179, гадаад 93162) зорчигч, жолоочид эрүүл мэндийн хяналт тандалт хийж, хилээр нэвтрүүлсэн. Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудсыг	<p>1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс, химийн болон цацрагийн осол хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт /-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангана.</p> <p>2. Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод тавигдаж буй хяналт тандалтын мэдээг сар бүр нэгтгэн удирдлага, холбогдох газруудад хүргүүлнэ.</p> <p>3. “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг</p>	<p>Монгол Улсын хилээр орсон 1,055965 (дотоод 825084, гадаад 230881), улсын хилээр гарсан 986931 (дотоод 822908, гадаад 164023) зорчигчдод эрүүл мэндийн хяналт, тандалтыг хийсэн нь өнгөрсөн мөн үеэс 60 хувиар нэмэгдсэн бөгөөд олон улсын хөл хориот өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй.</p> <p>Мал амьтны гоц халдварт өвчний тархалтын мэдээг холбогдох мэдээллийн эх сурвалжаас авч, 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан цахим сургалт дээр газар, хороодод чиглэл өгсөн.</p> <p>02-1.2/2450 дугаар албан бичгээр химийн осол, аюул гарахаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэл хүргүүлсэн.</p> <p>Цөмийн энергийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 14/498 “Хамтран ажиллах тухай” албан бичигтэй хавсарган хүргүүлсэн.</p> <p>Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудаст нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, ГЕГ-ын даргын 2024 оны 115 дугаар тушаалаар батлагдсан “Хилийн хорио цээрийг цахимжуулах ажлын хэсэг”-т өгч, программын даалгаврыг бэлэн болгосон.</p>	01.01-06.10	100
---	--	-------------------------	---	---	--	-------------	-----

			цахимжуулах үйл ажиллагааг “Гэрэг системс” ХХК-тай хамтран “Arrive mn” аппликашионыг боловсруулан үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.	хуудас”-д нэмэлт өөрчлөлт оруулах 4. Гэрийн тэжээвэр амьтан, цацрагийн дохионы бүртгэл, халдвартгуйжүүлэлт, шарилын бүртгэл, түр тусгаарлалт, зорчигч, тээврийн хэрэгслийн эрүүл мэндийн хяналтыг захиргааны статистикийн бүртгэлийн мэдээнд оруулах	Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймаг дахь Гаалийн газарт импортын бараанд гадаад хорио цээртэй ургамлын хорио цээрийн тохиолдол илэрсэн үед тухай бүр мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан. Халдвартгуйжүүлэлт, шарилын бүртгэл, түр тусгаарлалт, зорчигч, тээврийн хэрэгслийн эрүүл мэндийн хяналтыг захиргааны статистикийн бүртгэлийн мэдээнд оруулах программын даалгаврыг боловсруулсан. <b>Хүрсэн тувшин:</b> Гаалийн газар, хороодод зөвлөмж, чиглэлийг хүргүүлж ажилласнаар улсын хил, гаалийн хяналтын бүсээр хүний олон улсын хөл хориот өвчин, мал амьтны гоц халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй зүйлс дамжин тархаагүй, хими, цацрагийн осол, хордлого гараагүй.		
2	Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд хийх эрсдэлд сууринсан хяналт, шалгалт хийх ажлыг оновчтой зохион байгуулахад харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж хяналт тавих 2.Гаалийн хорио цээрийн чиглэлээр илрүүлсэн 230 зөрчил буюу системийн хэмжээний нийт 1362 зөрчлийн 16,6 % зөрчлийг	1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд хийх эрсдэлд сууринсан хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах, харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж хяналт тавих 2.Бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх үйл ажиллагааг зохион байгуулалтын бүтцийн бусад нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл	1.Гаалийн системийн хэмжээнд 2024.01.01-ний өдрөөс 2024.06.05-ны өдөр хүртэл хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоо <b>958</b> байна. Үүнээс <b>172</b> зөрчил буюу <b>18%-ийг</b> гаалийн хорио цээрийн хэлтэс, албаны гаалийн улсын байцаагчдын илрүүлэн <b>107.6 сая төгрөгийн</b> торгууль ногдуулж, шийдвэрлэсэн зөрчил эзэлж байна. 2023.01.01-ний өдрөөс 2023.06.05-ны өдөр хүртэл хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоо <b>793</b> , үүнээс <b>132</b> зөрчил буюу <b>16.6%-ийг</b> гаалийн хорио цээрийн хэлтэс, албаны гаалийн улсын байцаагчдын илрүүлэн <b>57.8 сая төгрөгийн</b> торгууль ногдуулж, шийдвэрлэсэн зөрчил эзэлж байсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоо <b>20.8 %-аар</b> өссөн бол гаалийн хорио цээрийн хэлтэс, албаны гаалийн улсын байцаагчдын илрүүлж, шийдвэрлэсэн зөрчил <b>30%-аар</b> , торгуулийн дүн <b>86%-аар</b> тус тус өссөн үзүүлэлттэй байна. 2. Бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх үйл ажиллагааг зохион байгуулалтын бүтцийн бусад нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай уялдуулан	01.01-06.10	95

		<p>холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн байна.</p> <p>3. Улсын хилээр орсон <b>229664</b> тээврийн хэрэгсэл (онгоц 1098, вагон зүтгүүр 2621, суудлын вагон 174, суудлын машин, автобус 34844, ачааны машин 190927)-д хяналт хийсэн Улсын хилээр гарсан <b>214901</b> тээврийн хэрэгсэл (1065 онгоц, 2720 вагон, 30472 суудлын машин, автобус, 180644 ачааны машин)-д хороо цээрийн хяналт хийсэн.</p> <p>4. Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хороо цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор Засгийн газар, яам, агентлагаас зохион байгуулсан 10 удаагийн уулзалт, хуралдаан, хэлэлцүүлэгт оролцож, 5 ажлын хэсэгт ажилласан байна.</p>	<p>ажиллагаатай уялдуулж ажиллана.</p> <p>3. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх</p> <p>4. Газар, хороодын ариутгалын байгууламжийн өнөөгийн судалгааг гаргах, холбогдох асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамаарах чиг үүргийн нэгжтэй хамтран ажиллах</p> <p>5. Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдвартгүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийж ажиллан, ариутгалын байгууламжийн өнөөгийн судалгааг гаргаж, Хуулийн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран ариуттал, халдвартгүйжүүлэлтийн ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж байна.</p> <p>6. Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хороо цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт оролцох, ажлын</p> <p>ажиллаж, зохион байгуулалтын нэгжид <b>182</b> дотоод зуравс хүргүүлж, <b>122</b> дотоод зурвасыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Харьяа газар, хороодод 12 албан бичгийг чиглэл тус бүрээр хүргэж, мэргэжлийн зэвлэгээ өгсөн.</p> <p>3. Гаалийн газар, хороодын хороо цээрийн үйл ажиллагааны тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/676 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу хороо цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын статистик мэдээг сар бүр хүлээн авч, нэгтгэн, нэгдсэн мэдээг Статистик, дүн шинжилгээний хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.</p> <p>4. Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдвартгүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийж ажиллан, ариутгалын байгууламжийн өнөөгийн судалгааг гаргаж, Хуулийн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран ариуттал, халдвартгүйжүүлэлтийн ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж байна.</p> <p>5. Гаалийн газар хороодоос 2024 оны эхний хагас жилд хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэлийн урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдвартгүйжүүлэлт хийсэн мэдээг хүснэгтийн дагуу авч, дүн шинжилгээ хийхэд: улсын хилээр орсон <b>446194</b> тээврийн хэрэгсэл (онгоц 1074, вагон зүтгүүр 1963, суудлын вагон 320, ачааны вагон 132195, суудлын машин 123745, ачааны машин 186897)-д урьдчилан сэргийлэх халдвартгүйжүүлэлт хийх явцад хяналт тавьж ажилласан нь нондингийн мэн үетэй харьцуулахад <b>48,6</b> хувиар нэмэгдсэн байна. Улсын хилээр гарсан <b>508030</b> тээврийн хэрэгсэл (1074 онгоц, 1947 вагон зүтгүүр, суудлын вагон 320, 128541 ачааны вагон, 124675 суудлын машин, 251473 ачааны машин)-д хяналт тавьж ажилласан нь нондингийн мэн үетэй харьцуулахад <b>57,6</b> хувиар нэмэгдсэн байна</p> <p>6. Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хороо цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт,</p>	
--	--	--	--	--

			5. ГЕГ-ын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд хорио цээрийн хэлтсээс тусгасан 5 сургалтыг харьяа гаалийн газар, хороодын улсын байцаагчдад зохион байгуулсан байна.	хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах  7. Харьяа гаалийн газар, хороодын улсын байцаагчдад сургалт зохион байгуулах	шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан 12 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцох, 6 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан нь өнгөрсөн мөн үетэй харьцуулахад уулзалт, хэлэлцүүлэгт 2-оор нэмэгдэж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байдал 1-ээр нэмэгдсэн байна.  7. ГЕГ-ын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд хорио цээрийн чиглэлээр ГЕГ-ын ЗББНДБ-ын албан хаагчдыг чадавхжуулах сургалт 4, харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдыг чадавхжуулах сургалт 10, нийт 14 сургалтын арга хэмжээ “жилдээ” төлөвлөгдсөнөөс биелсэн 4, хугацаа болоогүй 10 арга хэмжээ байна. 2023 оны эхний хагас жилд төлөвлөсөн 5 сургалтыг хийж байсан бол 2024 оны эхний хагас жилд төлөвлөсөн 1, төлөвлөгөөт бус 2, нийт 3 сургалтыг хийсэн байна. ХЦХ-ийн ГУБ нар 2024 оны эхний хагас жилд хорио цээрийн мэргэжлийн болон бусад чиглэлээр 11 сургалтад хамрагдсан байна.			
3	Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг чадавхжуулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Хилийн автозамын Замын-Үүд боомтын зорчигчийн терминаль ашиглалтад орсонтой холбогдуулан шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангасан байна.	1. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалтыг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр санал боловсруулж хүргүүлэх 2. Алтанбулаг, Боршоо боомтуудад бараа, тээврийн хэрэгслийг халдвартгийжүүлэх байгууламж барих ажлын даалгаврыг боловсруулах 3. Гаалийн газар, хороодод 8 ширхэг зорчигчийн халуун хэмжих термокамераар хангах зорилгоор	Хавирга, Цагааннуур, Булган боомтын өргөтгөл, шинэчлэлийн төслийн асуудлаар хэлэлцэж, “Нэг-Эрүүл мэнд” бодлогын хүрээнд хийгдэх ажлын саналыг Хилийн боомтын захиргаанд өгсөн. Бичигт, Булган, Арц-суурь, Шивээхүрэн, Сүмбэр боомтын өргөтгөлийн зураг төсөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл нийлүүлэлтэд санал ёгч, Боршоо, Алтанбулаг боомтын ариутгалын байгууламжийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан. Гаалийн 7 газар, хороонд 8 термокамера нийлүүлэх нээлттэй тендерийг шалгаруулж, нийлүүлэгч компанийг сонгож, худалдан авалт хийгдсэн. Газар, хороодын хорио цээрийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр шаардлагатай байгууламж, тоног төхөөрөмж, түргэвчилсэн үзлэг шинжилгээний 5 байгууламж 35 нэрийн 417 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн 12,019,560,411.3 төгрөгийн судалгааг төсвийн хамт гаргаж, 2025 оны төсвийн тодотголд оруулахаар хүргүүлсэн.	Хавирга, Цагааннуур, Булган боомтын өргөтгөл, шинэчлэлийн төслийн асуудлаар хэлэлцэж, “Нэг-Эрүүл мэнд” бодлогын хүрээнд хийгдэх ажлын саналыг Хилийн боомтын захиргаанд өгсөн. Бичигт, Булган, Арц-суурь, Шивээхүрэн, Сүмбэр боомтын өргөтгөлийн зураг төсөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл нийлүүлэлтэд санал ёгч, Боршоо, Алтанбулаг боомтын ариутгалын байгууламжийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан. Гаалийн 7 газар, хороонд 8 термокамера нийлүүлэх нээлттэй тендерийг шалгаруулж, нийлүүлэгч компанийг сонгож, худалдан авалт хийгдсэн. Газар, хороодын хорио цээрийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр шаардлагатай байгууламж, тоног төхөөрөмж, түргэвчилсэн үзлэг шинжилгээний 5 байгууламж 35 нэрийн 417 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн 12,019,560,411.3 төгрөгийн судалгааг төсвийн хамт гаргаж, 2025 оны төсвийн тодотголд оруулахаар хүргүүлсэн.	01.01-06.10	90

4	Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олголт, тэдгээрт хяналт тавьсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Импортын мэдэгдэл, экспортын гэрчилгээ авах хүсэлтийг www.caps.gaali.mn цахим хаягаар авч, бэлэн болсон гэрчилгээ, мэдэгдлийг цаасаар өгч ажилласан.	техникийн тодорхойлолт боловсруулах 4. Алтанбулаг, Боршоо боомтод амьд мал амьтныг түр тусгаарлаж, хорио цээрт оруулах байгууламжийг бариулах саналыг Сангийн яаманд хургуулэх	<b>Хүрсэн түвшин:</b> Хавирга, Цагааннуур, Булган боомтын өргөтгөл, шинэчлэлийн төслийн асуудлаар хэлэлцэж, "Нэг-Эрүүл мэнд" бодлогын хүрээнд хийгдэх ажлын санаалыг өгсөн. Бичигт, Булган, Арц-суурь, Шивээхүрэн, Сүмбэр боомтын өргөтгөлийн зураг төсөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл нийлүүлэлтэд санал өгч, Боршоо, Алтанбулаг боомтын ариутгалын байгууламжийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан. Гаалийн 7 газар, хороонд 8 зорчигчийн халууныг хэмжих төхөөрөмж нийлүүлэх нээлттэй тендерийг шалгаруулж, нийлүүлэгч компанийг сонгож, худалдан авалт хийгдсэн.	01.01-06.10	100

				<p><b>Хүрсэн түвшин:</b>          Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж, 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох, баталгаажуулах чиг үүрэг ХХААХҮЯ, МЭЕГ-т шилжсэн тул зөвхөн гаалийн газар, хороодоос олгох импортын гэрчилгээ олгох үйл ажиллагааг хялбарчлах, цахимжуулах программын даалгаврыг боловсруулсан.</p> <p>Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагаа, импортын гэрчилгээний олголтын талаар газар, хороодод цахимаар зохион байгуулсан 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаан дээр болон холбогдох албан бичгүүдээр чиглэл өгсөн.</p> <p>Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бараанд импортын мэдэгдэл 82 ш, экспортын гэрчилгээ 1506 ш, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд 903 ширхэг экспортын гэрчилгээ, дамжин өнгөрүүлэх мэдэгдэл 79 ширхэг, импортын мэдэгдэл 1175 ширхэгийг холбогдох хууль тогтоомжиднийцүүлэн, 2-4 цагийн хугацаанд шуурхай олгосон.</p> <p>Гаалийн газар, хороодод экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах, импортын гэрчилгээг хууль тогтоомжид нийцүүлэн шуурхай олгоход мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан.</p>	
--	--	--	--	--	--

5	Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн хилээр нэвтэрсэн 223690,7 тн, 118.981.558 ширхэг, 700 хайрцаг бараанаас 16096 удаа 50916,6 кг, 14597 ширхэг, 107,7 л барааг хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын шинжилгээнд хамруулахад 87842 үзүүлэлтээр шаардлага хангаж, 206 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна.	1.Хяналтын чиглэл бүрээр лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ, үзүүлэлтийн тайланг сар бүр нэгтгэн, удирдлагуудыг мэдээллээр хангах 2.Лабораторийн шинжилгээгээр зөрөг буюу шаардлага хангаагүй гарсан барааны дунд дун шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавина. Энэ чиглэлээр газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах 3.Лабораторийн итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулж хүргүүлэх	Хорио цээрийн хяналтад хамрагдсан барааны лабораторийн шинжилгээний дүн, мэдээнээс харахад нийт 532,8 мян.тн, 6.355.978 ширхэг, 54 хайрцаг бараанаас 12118 удаа 27,7 тн барааг шинжилгээнд хамруулсан байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бараа нь 61946 үзүүлэлтээр шаардлага хангаж, 106 үзүүлэлтээр шаардлага хангаагүй гарсан нь урьд оны мөн үеэс 27 үзүүлэлтээр илүү байна. Лабораторийн итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулан ажиллаж, МЭЕГ, ХАБУЛЛ зэрэг төрөлжсөн лабораторийн удирдлагуудтай ГЕГ-ын даргын 2024 оны 115 дугаар тушаалаар батлагдсан Хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсэг уулзалт хийж, цахимаар өгөгдөл солилцох асуудал дээр тохиролцов. <b>Хүрсэн түвшин:</b> Хорио цээрийн хяналтад хамрагдсан барааны лабораторийн шинжилгээний дүн, мэдээнээс харахад нийт 532,8 мян.тн, 6.355.978 ширхэг, 54 хайрцаг бараанаас 12118 удаа 27,7 тн барааг шинжилгээнд хамруулсан байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бараа нь 61946 үзүүлэлтээр шаардлага хангаж, 106 үзүүлэлтээр шаардлага хангаагүй гарсан нь урьд оны мөн үеэс 27 үзүүлэлтээр илүү бөгөөд шаардлага хангаагүй барааг буцаах, устгах зэрэг холбогдох арга хэмжээг авсан байна.	01.01-06.10	100
8	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Удирдлагын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврууд, ХШҮДАГ-аас өгсөн 3 зөвлөмж, онлайн хурлаас өгсөн эрсдэлийн удирдлагатай холбоотой 1 үүрэг даалгавар, Мэргэжлийн	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллан тайлagnана.	СЭРП программын “Үүрэг даалгавар” хэсэгт нэгжтэй холбоотой 16 үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтийг гаргаж, илгээж, дүгнүүлсэн.	01.01-06.10	100

			зөвлөлийн хурлын 2 шийдвэрийн биелэлтийг СЕРП программаар хугацаанд нь хүргүүлсэн.			
9	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр Ажлын цаг ашиглалтын оноогоор	Ажлын цаг ашиглалтыг 100 хувь ханган ажилласан.	Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. Ажлын цаг ашиглалтыг 100 хувь хангана.	Ажлын цаг ашиглалтыг сайжруулан, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн ажилласан, шалтгаангүйгээр ажил таслаагүй.	01.01-06.10 100
10	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Үндсэн чиг үүрэгт тусгагдаагүй дараах 5 ажлыг гүйцэтгэсэн	ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог удирдлага арга зүйгээр хэрхэн хангаж ажилла  Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, төрийн болон төрийн бус болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах	Буудайн гурилын импортын татвараас чөлөөлж, импортын мэдэгдлийг шуурхай олгох, химийн хортой болон аюултай бодисын хадгалалт устгал, эмийн хяналтын асуудал зэргээр тухай бүр гаалийн газар, хороодод чиглэл өгч ажилласан. ЭМЯ, ХХААХҮЯ, ЭЗХЯ болон бусад мэргэжлийн байгууллагатай цартахлын дараах төлөвлөгөө, импортын барааны эрсдэлийн үнэлгээ, уул уурхайн бус барааны экспортыг нэмэгдүүлэх, цахимжилт зэрэг асуудлаар хамтран ажиллаж, энэ чиглэлээр гаалийн газар, хороодод мэдээлэл өгч уялдуулж ажилласан. <b>Хүрсэн түвшин:</b> ЭМЯ, ХХААХҮЯ, ЭЗХЯ болон бусад мэргэжлийн байгууллагатай цартахлын дараах төлөвлөгөө, импортын барааны эрсдэлийн үнэлгээ, уул уурхайн бус барааны экспортыг нэмэгдүүлэх, цахимжилт зэрэг асуудлаар хамтран ажиллаж, энэ чиглэлээр гаалийн газар, хороодод мэдээлэл өгч уялдуулж ажилласан.	01.01-06.10 100

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь

	1	2	3	4	5	6	7
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	-	<p>-Монгол Улс, БНСУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээрийн ажлын хэсгийн SPS -ийн ажлын хэсгийг ахлан уулзалт, хэлэлцээрийг хийж ажиллах явцад ГХЯ, ЭЗХЯ, ХХААХҮЯ-наас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад хамрагдсан -2024 оны эхний хагас жилд Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах арга хэмжээг төлөвлөөгүй боловч дараах цахим сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн. Үүнд:</p> <p>-2024.03.07-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг танилцуулах “7:4:10” цахим сургалт</p>	01.01-06.10	100
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандaa нэвтрүүлсэн байна.	<p>-Шинээр батлагдан гарсан дараах хууль, тогтоол, журмыг тухай бүр бие даан судалж, албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандaa нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон хууль 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийг судалж, холбогдох журам зааврын өөрчлөлтийг хийх ажлын хэсэгт орж ажилласан.</p> <p>Эм, эмнэлгийн хэрэгсийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр УИХ-аар эцэслэн батлагдаж, уг хууль 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үе шаттайгаар хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан хуулийн холбогдох заалтуудыг судалсан.</p> <p>Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэгт ажиллан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 3 удаагийн хурлаар, УИХ-ын чуулганы 2 удаагийн хурлаар тус тус хэлэлцүүлэн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр эцэслэн батлуулсаны дагуу хуулийг хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийсэн.</p>	01.01-06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

/Г.БАТМОНХ /

2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

1550

**ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ГОНЧИГЖАВ ОВОГТОЙ БАТМӨНХИЙН  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,  
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТУВШИНГ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн өрөнхий газар  
Нэгжийн нэр: Хорио цээрийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилго, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		57.3

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах		14
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх		14
<b>Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо</b>			14

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй		14
2	Удирдан зохион байгуулах		14
3	Асуудал шийдвэрлэх		13
4	Манлайлах		13
5	Багаар ажиллах		13
6	Харилцаа		15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
7	Мэргэжлийн ур чадвар 1.		14
<b>Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо</b>			14

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	57.3
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14

3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	14
4	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	
<b>Нийт оноо=</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		85,3

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч:

(Р. Отгонжаргал)

2024. 06. 19

(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Хорио цээрийн хэлтсийн дарга

Нэгжийн дарга:

(Г.Батмөнх)

2024. 06. 22 (огноо)